



## САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2019 оны 09 сарын 11 өдөр

Дугаар 258

Улаанбаатар хот

### Гүйцэтгэх захирлын албан тушаалд томилохыг зөвшөөрөх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.2.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.1.9, Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 04 дүгээр тогтоолоор баталсан “Үнэт цаасны зах зээлийн зохицуулалттай үйл ажиллагааны багц дүрэм”-ийн нэгдүгээр хавсралт “Үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам”-ын 6.24 дэх хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Ди Би Эм ассет менежмент ҮЦК” ХХК-ийн гүйцэтгэх захирлын албан тушаалд Дамдин овогтой Болормааг томилохыг зөвшөөрсүгэй.
2. Гүйцэтгэх захирлыг өөрчлөн томилсонтой холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг “Ди Би Эм ассет менежмент ҮЦК” ХХК /Д.Болормаа/-д үүрэг болгосугай.
  - 1/ Улсын бүртгэлийн гэрчилгээнд тэмдэглэгээ хийлгэж, холбогдох баримт бичгийг ажлын 15 хоногийн дотор Санхүүгийн зохицуулах хороонд ирүүлэх;
  - 2/ Хөрөнгө оруулагч, харилцагчдын хууль ёсны эрх ашгийг дээдлэн холбогдох хууль тогтоомж, дүрэм, журмыг үйл ажиллагаандаа чанд мөрдөж ажиллах;
3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Б.Ариунаа/-нд даалгасугай.

ДАРГА

С.ДАВААСҮРЭН